



**ХЭНТИЙ АЙМГИЙН  
БЭРХ ХОТЫН ЗАХИРАГЧИЙН  
ЗАХИРАМЖ**

2026 оны 02 сарын 05 өдөр

Дугаар А/09

Бэрх хот

**Хяналт, шалгалт хийх  
ажлын хэсэг томилох тухай**

Монгол Улсын “Хот тосгоны эрх зүйн байдлын тухай” хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх заалт, 30 дугаар зүйлийн 30.1.33 дах заалт, “Төрийн хяналт шалгалтын тухай” хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, 8.3.1 дэх заалт, “Хүнсний тухай” хуулийн 5 дугаар зүйлийн 5.4 дэх заалт, Хэнтий аймгийн Хүнс хөдөө, аж ахуйн газрын даргын 2026 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн 03/46 тоот албан бичиг, Хэнтий аймгийн Цагдаагийн газар, Хэнтий аймгийн Цагдаагийн газрын даргын 2026 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн “Цахим архи худалдаа” тусгай арга хэмжээний хүрээнд хамтарсан хяналт, шалгалт явуулах ажлын удирдамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Цагаан сарын баяртай холбогдуулан хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчийн хүнсний аюулгүй байдал, учирч болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх зорилгоор тус хотын худалдаа, үйлчилгээ эрхлэгч байгууллагад 2026 оны 02 дугаар сарын 05-ны өдрөөс 02 дугаар сарын 11-ний өдрийн хооронд хяналт шалгалт хийх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Ш.Ганцэцэг (ЗАА-ны Хүнс, жижиг дунд үйлдвэр, хоршооны асуудал хариуцсан мэргэжилтэн)

Гишүүд: Б.Болорцэцэг (ЗАА-ны Татварын улсын байцаагч)  
Д.Оюунтүлхүүр (ЗАА-ны Хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан)

Б.Энхдөл (ЗАА-ны Байгаль хамгаалагч)

М.Мөнх-Эрдэнэ (Батноров сумын сум дундын цагдаагийн тасгийн хэсгийн төлөөлөгч, цагдаагийн ахлах дэслэгч)

2. Заагдсан хугацаанд хяналтыг чанартай зохион байгуулж, дүн мэдээг Хэнтий аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газарт 2026 оны 02 дугаар сарын 24-ний өдөр хүргүүлэхийг ажлын хэсгийн ахлагч, гишүүдэд үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захирагчийн орлогч (Н.Бахыт)-д даалгасугай.

ЗАХИРАГЧ  Ч.ЭНХЖАВХЛАН

232 601 015